

МОНГОЛЧУУДЫН ЗАГАСТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ОЙЛГОЛТЫН ТУХАЙД

Залгаахүү

Товч агуулга: Монголын зарим аймаг угсааныхан эртдээ загас агнуурын аж ахуйг зохих хэмжээнд эрхэлж байжээ. Энэ дундаа загастай холбоотой аман зохиол, зан үйлийн өвөрмөц соёлыг бүрдүүлжээ. Монголчуудын загасны тухай эртний зарим нэг ойлголтыг задлан шинжлэх нь сонирхолтой сэдэв болно.

Түлхүүр үг: *Монголчууд, загасны тухай ойлголт*

Эрдэмтэн С.Бадамхатан “Хөвсгөлийн дархад ястан” бүтээлдээ дархадын загас агнуурын тухай тусгай хэсгээр тэмдэглэн бичжээ. Тэрээр загасчлах ажил нь дархадуудын дунд нэлээд нөлөөтэй байсан боловч “тэдний ахуй, хэв заншилд загасны холбогдол бүхий эртний нийгмийн үзэл санааны зүйл хадгалагдаагүй байгаа явдал маш сонирхолтой тул дахин тодруулан судлах хэрэгтэй юм (2011) гэжээ. Аман зохиолын эрдэмтэн Мандах профессор миний докторын хамгаалалтын үед “Монголчуудын дунд загасны тухай үлгэр домог тун цөөн байдаг. Чиний өгүүлэлд нэлээд хэдэн домгийг олж ашигласан нь сонирхолтой байна. Үргэлжлүүлэн тусгайлан судалж болно” гэж сануулсан билээ. Эрдэмтдийн сануулгаас сэдэл авч энэ тухай материал сэлт анхааран судалсан юм. Монголчуудын дунд загасны тухай тэмдэглэл, материал ховор боловч, анхаарч үзвэл загас нь монголчуудын өдөр тутмын үйлдвэрлэл, амьдрал төдийгүй аман зохиол, зан үйл зэрэгт ч холбоотой. Иймээс загасны тухай монголчуудын зарим нэг ойлголтыг тодруулж, загасны соёлыг судлах нь ач холбогдолтой юм.

Эртний монголчууд загасны шим тэжээл, үнэ өртгийг ухаарч, үйлдвэрлэл амьдралдаа хэрэглэж байсан тухай “Дээр үед загасны шөл чийг бам болон бусад аливаа нэгэн өвчин эмгэгт сайн гэж хэлэлцдэг байжээ. Иймээс загасны махыг гол төлөв анагаах, сувилалд зорилготойгоор хэрэглэдэг. Мөн ийм зорилгоор ядарч эцсэн малд өгөх юм уу, шөлийг нь цутгаж уулгадаг байсан” (Бадамхатан С. 2011) гэсэн тэмдэглэл бий. Үүнээс үзэхэд загас агнуур эрхэлж байсан зарим угсаа ястад нь загасаар амьдралын үндсэн хэрэгцээгээ хангах төдийгүй эм эмнэлэг, шим тэжээлийн зэрэг үнэ өртгийг нь ойлгож өөрийн амьдралдаа ашиглаж байжээ. Загас нь ингэж монголчуудын үйлдвэрлэл, амьдралд чухал үйлдэл үзүүлж байсны зэрэгцээ тэдний үзэл санааны ертөнцөд ч шимтэн орсон байдаг. Доор бид монголчуудын загасны аж ахуйд үндэслэсэн соёлыг аман зохиол, зан үйлийн хараасаар шинжилж, загасны тухай эртний үзэлт, ойлголтыг задлан өгүүлэе.

Нэг. Монголчуудын загасны аж ахуй

Монголчуудын загасны аж ахуй нь маш эртний улбаатай байжээ. Тухайлбал: “Шинэ чулууны үеийн хүмүүс төрөл бүрийн араатан гөрөөсийг намнан авлахын зэрэгцээгээр загасчлах болсон нь урьд үеийг бодвол нэлээд ахицтай байжээ. Дорноговь аймгийн Дулаан

говь, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Өмнөговь аймгийн Баянзаг сум, Увс аймгийн Зүүнговь сум зэрэг бас бус газраас загасны торны зэвүүр чулуу, чулуун элбээс загас олджээ. Тэдгээр зэвүүрийн ихэнхийг нүхэлж хийжээ. Олслог ургамлаар загасны тор нэхэх болсон” (БНМАУ-ын түүх, 2009) гэх зэрэг тэмдэглэл бий. Үүнд, Монголын олон нутагт загас агнуур эрхэлж байсныг мэдээлснээс гадна загасчлах ажил нь нэлээд хөгжилтэй байсныг мэдэж болно. “Дорноговиос чулуугаар хийсэн загасны дүрс, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутгаас тариа үлтэлдэг загасны хэлбэртэй самбар чулуу олдсон нь загас агнуур эртний ус нуур бүхий газар хөгжсөний дурсгал бөгөөд загасчлах ажил бас урлагт дүрслэгдэх болсны гэрч юм” (БНМАУ-ын түүх, 2009). Загас агнуур нь дээр үеийн монголчуудын чухал нэгэн аж ахуйн хэлбэр болж байсан нь эргэлзээгүй ээ. Цаашлаад Монголчуудын дунд нэн эртний эх сурвалжтай байсан тухай “Энэтхэгийн дунд хэсгийн Лилер хотны орчмоос илрүүлсэн он тооллоос өмнөх 2500-2600 оны үеийн хадны зурагт онцгой сайхан угалзтай монгол хувцастай эмэгтэйчүүд, морь унасан худалдаачид ба тариа тарьж, загас агнан, арилжаа хийж байгаа монгол хүний амьдралын зургийг дүрсэлсэн” (Амгалан А. 1994) мэдээлэл бий. “Тус хадны зургаар баримжаалан үзвэл загас агнах үйлс Монгол оронд буй болоод наад захдаа 4600 жилээс цаашид түүхтэй байж болно” (Амгалан А. 1994). “Шинэ чулууны үед нэлээд дэлгэрч байсан анхны урлагийн нэгэн болох хад чулуунд буга, адуу, загас зэрэг ан амьтдыг дүрслэн зурах, сийлэх болсон нь нэг талаараа ан гөрөөний олз омог элбэг байгаасай гэж ерөөсөн шүтлэг тахилгын гэрч болохын дээр, нөгөө талаар тэр үеийн аж ахуйн нэгэн салаа мөчир *агнуур, загасчлал, малжих ажил* их ахицтай хөгжиж байсныг үзүүлж байна” (БНМАУ-ын түүх, 2009) гэж археологичид дүгнэжээ.

Загас агнуур нь ингээд зогсонгорсон биш, харин “Монголын хүрлийн үеийн хүмүүс бас загасчлах ажил эрхэлдэг байжээ. Сэлэнгэ мөрний савд малтсан булшнаас загасны яс, загасны ясан харвуулын зэв, гарчээ” (БНМАУ-ын түүх, 2009). “Хүрлийн үед холбогдмоор загасны хүрэл цутгамал дүрснүүд Өмнөговь аймгийн нутгаас олдсон нь тэр цагт загасны агнуурын ажил, аж ахуйн салаа мөчрөөс бүрэн шахагдан гараагүй, аж ахуйд чухал үүрэг гүйцэтгэж байсны гэрч болно” (БНМАУ-ын түүх, 2009). Монгол үндэсний түүхэн тулгуур бичиг МНТ-д

“Зарчимтай Өүлэн эхийн

Загасаар тэжээгдэгсэд хөвгүүд

Засагт цэцэд болов” (Баяр. 2012)

“Эх юүгээн тэжээе хэмээлдэж

Эх Ононы эрэг дээр сууж

Өлгүүр гөх засалдаж

Эрэмдэг зэрэмдэг загас өлгөж, гүйхэлж

Зүүгээр гөх эгүүлж

Зэвх хадраа горхилж

Цэлэм гогцоор уяж

Заримд занас шүүж

Жич эх юугаан ач тэжээв” (Баяр. 2012) гэж гардаг. Үүнээс тэд нэгэнт загас барих мэргэжилд нэлээд боловсронгуй болсныг мэдэж болно. МНТ-д бас “Нэгэн өдөр Тэмүүжин, Хасар, Бэгтэр, Билгүүдэй дөрвүүл хамт сууж гөх татахуй дотор нэгэн гэгээхэн аугсан оршихуй. Тэмүүжин, Хасар хоёроос Бэгтэр, Билгүүдэй хоёр булааж авав” (Баяр. 2012) гэх явдлыг тэмдэглэжээ. Энэ нь тухайн үед загас нь Тэмүүжин нарын амьдралд маш чухал хэрэгцээтэй байсныг харуулжээ. “10-р зууны үеэр Хятадын цагаан хэрмээс Байгаль нуур хүртэлх өргөн уудам нутагт, анхны хүй нэгдлийн үед гөрөөчин, загасчин отог... аймаг угсаа тархан амьдарч байсан” (БНМАУ-ын түүх, 2009) гэх буюу “Халгиун мөрөнд загасчин, хэрэмчин, гөрөөчин бүлэг цөлөг иргэд 12-р зууны сүүлч хүртэл амьдарч байжээ (БНМАУ-ын түүх, 2009) гэх мэдээлэл бий. МНТ-д бас “Тогтоа бэхийг хэвтээ бөгөөтөл хүрэхийг Халгиун мөрнөө бүхэн загасчин, булгачин, гөрөөчин тавигсад (дайн аялш) хэмээн шөнө дөлийн хэлэн

хүргэж очихуй” (Баяр. 2012) гэж гардаг. Эдгээр баримтаас үзэхэд Монгол аймгийн дунд тусгайлсан загас агнан амьдардаг “загасчин отог” гэж буй болсон байна.

“Хубилай хааны үед Шанд нийслэлийн зүүн ба баруун сэрүүн ордныг байгуулж, намрын авыг Шанд хотын тойронд хийдэг байжээ” (Цэрэнжав. 2007). “Баруун сэрүүн ордон нь Монголчууд угаасаа “Цагаан голын ордон” гэдэг Луан Хэ гол (*одоогийн Шандын голын хөвөөнд бий*) голын хоёр хөвөөгөөр авын шонхор тэжээдэг болохоор “Шувууч” гэдэг. Зүүн сэрүүн хотыг (Өвөр Монголын Долоннуур сяний Ар цагаан хот) 1315 онд хангалтыг хамаарах ордон болгон тусгайлан байгуулж эзэн хааны Шанд нийслэлийг тойрон явахад үйлчлэх нүүдэл авын газар байжээ. Зүүн сэрүүн ордныг “Загас балгас” (17) гэнэ. Энд хэдийгээр зүүн сэрүүн ордны нэрсийн гарлын талаар тодорхой тайлбарласангүй боловч баруун сэрүүн ордныг “Шувууч” гэж нэрлэснээс мөрдөж үзвэл “Загас балгас” гэсэн нь загас элбэг байсан газар буюу загас агнууртай холбоотой нэрийдэл гэж үзэж болмоор байна. Б.Я.Владимирцовын “Монголчуудын нийгмийн байгууллын түүх”-д “Ойн иргэн голдуу ан гөрөө хийдэг боловч загас барихыг бас омтголддоггүй” (2012) гэжээ. “Тэр үед Монголын ойн иргэний аймгууд нь Байгал нуурын хөвөө, Енисей мөрний дээд сав газар ба Эрчис мөрний дагуу нутаглаж байжээ” (Владимирцов 2012). “Тол мөрний болон нуурын хөвөөгөөр нутагладаг аймгууд ялангуяа Татаарын зарим хэсгүүд болон ойн иргэд загасчлах нь түгээмэл байсан юм” (Далай Ч. 2012). Мөн гол мөрөн дагуу нутаглаж байсан аймгуудын аж ахуйд загас агнуур нь чухал байр суурьтай байжээ. “Хөвсгөл далайн дагуу нутаглаж байсан дархадуд авч хэлбэл загасчлах явдал үе уламжлагдан хадгалагдаж ирсэн аж ахуйн амьдралын нэгэн хэлбэр мөн” (Бадамхатан С. 2011) бөгөөд дархадын загасчлах хэрэгсэл их хөгжиж байсан тухай С.Бадамхатан “Хөвсгөлийн дархад ястан” номдоо тусгай хэсгээр, нарийн тэмдэглэжээ. Энэ номд бас дархадын загасчлах хэрэглэл нь Тува, Буриадынхтай ижил төстэй гэж танилцуулсан нь Тува, Буриадуд загасчлах ажил эрхэлж байсныг нотолжээ. Шулуун хөх хошууны адууны тамганд “Зөрмөл загасан тамга, өрөөсөн нүдэт зөрмөл загасан тамга, дээрээ сартай зөрмөл загасан тамга, зөрмөл сохор загасан тамга, гурван нүдэт загасан тамга, дэвсгэртэй загасан тамга, дан загасан тамга, гурван зөрмөл загасан тамга” (Цэрэнжав. 2007) зэрэг загасан тамгуудыг хэрэглэж байсан тодорхой тэмдэглэл бий. Энэ нь загас агнууртай холбоотой соёлын үзэгдэл гэж үзэж болно.

Загас агнуурыг эрт үеэс үүссэн гэдэг боловч нийт монголчуудыг хамаарч байгаагүй. Гол мөрний дунд нутаглаж байсан овог угсааны дунд нэлээд хөгжиж байсан ч цөөн хүмүүсийн эрхэлдэг ажил байсан буюу туслах маягийн аж ахуйн хэлбэр байжээ. Монголчууд “*мал аж ахуй*”-г эрхлэх болсноос загас агнуур аажмаар бууралтад оржээ. Гэвч дээр өгүүлснээр зарим угсаа аймгууд загас агнуурыг ихэд хүндэтгэж байсан түүхтэй мөртөө тэдний амьдралд олон талаар нөлөөлж байсан юм. Энэ тухай аман зохиол, зан үйлийн соёлд тодорхой тусгагдсан байна.

Хоёр. Загас ба аман зохиолын соёл

Загасыг эртний Монголчууд өдөр, шөнө ялгалгүй нүдээ аньдаггүй өвөрмөц сонор соргог амьтан, өсөж үржихдээ хурдан гэж эрхэмлэн үздэг заншилтай юм, “Буриад бөө нар баавгайг уулны хүн, загасыг усны хүн” (Аюурзана Г. 2016) хэмээн үздэг. Энд баавгай, хун шувуу, загас зэргийг бүр хүнээр үзэж байна. Урианхай, торгуудын үлгэрт “Эрт урьд мангас бүх хүнийг идэж дуусаад эмгэн, өвгөн хоёр л үлджээ. Мангас тэр хоёрыг идэхээр очиход, тэд зугтаж, өвгөн нь ойд гарч баавгай болж, эмгэн нь усанд орж загас болсон” (Аюурзана Г. 2016) гэж өгүүлдэг. Энэ үлгэрт хүн загас болсон өгүүлэмж бий. Эрдэмтэн Цэрэнсодном “Баавгай, загас мэтийн амьтдыг хүнээс гаралтай хэмээн тайлбарласан зүйл монгол үлгэрт тохиолддогийг тухайн овог аймгийн шүтээн буюу “тотемын үзэл” гэж үзвэл зохино” (1989) гэжээ. Хүний үүслийг ямар нэгэн амьтантай холбон өгүүлэх буюу амьтны үүслийг хүнтэй холбон өгүүлэх нь бүр маш эртний домог сэтгэхүйн нөлөө ба тухайн овог аймгийн тотемын үзэлтэй холбоотой юм. Дэлхийн явган үлгэрийн хэв шинжийн ангилалд (АТ705) “загаснаас

төрсөн” гэх хэв шинж байдаг. Энэ нь загаснаас хүн үүссэн гэх нь дэлхий нийтийн чанартай домгийн өгүүлэмж болохыг нотолжээ. Жишээлбэл: Хэжэ үндэстэн “И Ма Хагийн (Хэжэ үндэстэн загасыг И Ма Ха гэдэг) хойчис” гэдэг домогт өгүүлснээр “Эрт урьд цагт, дөрвөн зүгт юу ч үгүй, тэнгэрийн доор зөвхөн шавар шороо ба далай тэнгис байж гэнэ. Тэнгэрийн сахиусан Энд үр далайн усаар шавар шороог зуурч, нэгэн том загас барьж гаргав гэнэ. Залгаад бас хөл гартай, нүд хамартай, уруул чихтэй, 18 жижиг шавар хүн бариад наранд хатааж байтал, гэнэт бороо орж эхлэв. Тэнгэрийн сахиусан сандрахдаа тэдгээр хүмүүсээ тэр том загасны аманд хийж оруулсан гэнэ. Тэнгэр цэлмэсний дараа тэнгэрийн сахиусан шавар хүнээ гарган авч, хатаах гэтэл тэдгээр хүмүүс нь загасны амнаас өөрсдөө үсэрч харайсаар гарч ирсэн гэнэ (Хун Рэн Юань. 2000). Тус домогт шавар хүн нь загасны амнаас гарч ирэхдээ амилсан байна. Загас нь амийн үүсгэл, үржлийн үндэс болж буй. Шивээ үндэстний дунд яригддаг “Мөрөг загасны хувилгаан” гэдэг домогт бас “Эрт урьд цагт нэгэн хөлсний тариачин мөрөг загасны амийг аварчээ. Тэгэхэд мөрөг загас нь сайхан бүсгүйд хувилж, тариачинтай хуримлажээ. Хорон санаатай газрын эзэн хөлсний тариачныг жигнэж алах гэсэнд “мөрөг загасны хувилгаан” бие хамгаалах эрдмийн хайраа өгснөөр хэчнээн гал түлсэн ч анзаарсангүй гэнэ. Газрын эзэн учрыг мэдээд, тариачны хувцсыг тайлан чанасанд Мөрөг загас бас увдис гарган аварчээ. Тэгээд хоёулаа өндөр уул, балар шугуйд зугтан хүрч, аз жаргалтай амьдарч нэгэн хүү төрүүлжээ. Түүнээс “Шивээ” үндэстэн үүсэж, үржин олширч, үр удам нь дэлгэрсэн гэнэ” (Хун Рэн Юань 2000). Энэ домогт шивээ үндэстний дээдсийг загастай холбон тайлбарлаж буй. Мөн дээдсээ болгон домоглож байгаа тотемын үзэл болно.

Дэлхий нийтийн гаралтай иймэрхүү домгийн өгүүлэмж нь монголчуудын домогт түгээмэл байдаг билээ. Шинжааны Ойрад монголчуудын дунд газар дэлхийг бүтэснээс хойш нарны илчээр хорхой шувуу гараад, түүнээс загас гараад, загаснаас хүн бүрэлдэн гарсан юм” (Зохиогчийн 2005 оны Хээрийн Шинжилгээний тэмдэглэлээс) гэдэг. Бөө мөргөлийн шүтлэг ихтэй буриадуудын дунд эрт цагт удган эхнэртэй нэг бөөгийнд хүүхэд төрсөнгүй. Хүүхдийн мөрөөдөл болсон эр гадаад далайн нохой эртний улсад очиж нэг удганаас үрийн сүнс гуйжээ. Тэр удган түүнд эр, эм хоёр загас өгчээ. Хүүтэй больё гэвэл эрэгчин загасыг, охинтой больё гэвэл эмэгчин загасыг идүүлээрэй гэжээ. Бөө зам зуураа эцэж ядраад, өлсөөд эмэгчин загасыг идэж орхижээ. Энэ хорвоо дээр эхний бөгөөд эцсийн удаа эр хүн нярайлсан тохиолдол гарч, тун цэвэрхэн сайхан охин мэндэлжээ. Дараа нь удган эхнэр нь хүү төрүүлжээ (Аюурзана Г. 2016) гэж гардаг. “Загас идээд жирэмсэлсэн” гэдэг нь сонирхолтой байна. Иймэрхүү маш эртний улбаатай сэрлээр жирэмслэх өгүүлэмж домогт байдаг билээ. Эдгээр домогт загас нь амийн үүсэл, хүний үүслийн эх болж байна. “Монгол бөөгийн шашинд загас нь лусын амьтан, үрийн хутгийн сахиус байдаг” (Пэрлээ Б. 2013) гэжээ. Загас нь бас хүн ам өнөр өсөхийн бэлгэдэл мөн. “Хавар загас нуур голын хөвөөнд яраглаж өндөглөдөг, загасны өндөг олон байдаг тул үүгээр үр хүүхэд олон заяахыг язгуур эртний хүмүүс бэлгэдэж, загасаар үрийн хутгийн сахиус болгож байсантай холбоотой ажээ (Пэрлээ Б. 2013).

Бөө мөргөлийн шүтлэгтэй байсан монголчуудын хувьд лусын амьтан загас нь тэдний үйлдвэрлэл, амьдралын зан үйлийн олон талтай холбоотой байсан нь ийнхүү эртний домогт тусгагдаж байжээ. Жишээлбэл: Монгол улсад яригддаг нэгэн домогт “Нэг их усан дотор хоёр загас амь сүүлээрээ хөхөлдөн цагариг хэлбэртэй байв. Тэр хоёр загасны хооронд цугларсан элс шорооноос “Сүмбэр уул” ургасан гэнэ. Бид тэр хоёр загасны биеэс бүтсэн дөрвөн тивийн хамгийн гадна талд аж төрөн сууцгаадаг юм байна. (Цэрэнсодном Д. 2013) гэжээ. Энэ домогт загас нь газар дэлхийн үүсэлтэй холбогджээ. Энэ мэтчилэн Хөхнуурын Хошууд монголчуудын нэгэн домогт “Дэлхий дээрх хамгийн бандгар (том) юм бол загас болно. Энэ газрын бөмбөрцөг нэг бандгар загасны дээр тогтож байдаг гэнэ. Иймээс энэ загас нь ядарч биеэ шилгээвэл газрын бөмбөрцөг бас дагаад хөдөлдөг гэнэ (33) гэж байгаа нь монголчуудын загасны үйлдвэрлэл амьдрал дахь байр суурийг харуулж чадахуйц эртний домог сэтгэхүй болох юм.

“Алтан загас хүүхэн” (Сарнай Ч. 2013), “Загас аварсан залхуу шар” (Нармай, 2008), “Гунан хар хүү хааны хүргэн болсон нь” (Төмөрбөх. 2004) зэрэг аман үлгэрүүдэд бас “Хүн загасыг аварсан нь, загас хүний ачийг хариулсан нь, загас хүнтэй урагласан нь” гэсэн өгүүлэмжүүд байдаг.

Монгол ардын зохиолын онцгой нэгэн хэлбэр болох ертөнцийн гуравт:

“Идээний эх цай

Эдийн эх хадаг

Амьтны эх загас” гэдэг нь загасыг аливаа амьтан голтын эх үүсэлтэй холбоотой гэж үзэж байгаа ухамсарт сэтгэлгээ болох юм. “Намар 9-р сарын үед цагаан загас үрээ хаях гэж бөөнөөр гол өгсөж, 10-11-р сард буцаж нуурт эргэдэг. Үүнийг дархад хүмүүс “загасны наадам” гэж нэрлэдэг байна (Бадамхатан С. 2011). Монголчуудын эртний соёлын хэллэг “энгэр зөрүүлэх”-ийг “загас наадуулах” гэж хэлдэг. Үүнээс авч үзвэл загас, түүний амьдралын явц, түүнтэй холбоотой мэдлэг өргөн байсны гэрч юм. Монгол улсын “төрийн соёмбо”-д хос загасны бэлгэдэл бий.

“Хүн хүний хүчинд

Загас усны хүчинд”,

“Зан сайтай хүнд нөхөр олон

Замаг сайтай усанд загас олон” зэрэг зүйр цэцэн үг дэлгэрсэн нь монголчуудын эртний загасны соёлын суурь дээр буй болсон юм.

Гурав. Загастай холбогдох зан үйл

Лувсанчойдоны “Монгол зан аалийн ойлбор”-т тэмдэглэснээр “Их эрт цагт тэнгэрийг шүтэж, уул усан дур аливааг даатган явж байсан цагт олноор чуулга болж, уул буюу их мөрөн, гол буюу эс бөгөөс их нуур буй. Эдгээр газрыг сонгож тахилгын орон болгож, их хүндэтгэмүй. Хэрвээ нуурыг тахисан хойно хэрхэвч тахисан нуурын загас амьтныг хүнээр бариулахыг огт болохгүй цээрлэмүй” (Лувсанчойдон. 1981) гэжээ. Монголчууд гол мөрөн, нуур тойрмыг шүтэж, тахидаг нь маш эртний уламжлалтай. Эдүгээ хүртэл уламжлагдсаар байгаа “Орхон голын магтаал”, “Хөвсгөл далай ээжийн дуудлага” зэрэг тахилга, тайллагын дуудлага нь үүний нэгэн гэрч мөн. Монголчууд ер нь уул нуруу, гол мөрөн, нуур тэнгис бүхэн эзэд сахиустай гэж сүсэглэж биширдэг ба ямар нэгэн ид шидтэй бөгөөд далд оршдог навдаг, савдагтай гэж үздэг. Иймээс зарим амьтныг “уулын эзэн”, “усны сахиус” гэж үздэг. Үүнтэй холбоотойгоор тахисан нуурын загасыг дураараа барьж болохгүй гэсэн цээрийн ёсон гарчээ.

Монголчууд загасыг “газар усны эзэн” хэмээн төсөөлдөг. Тухайлбал: Хүрээ хошууны хар ус нуурын эзэн нь “Могой загас” гэж ярьдаг (Хүрэлшаа. 1993). Хөхнуурын монголчууд “Загас алж болохгүй. Нэг загас албал мянган загасны хилэнцтэй тэнцэнэ” (Сарангэрэл. 2012) гэж цээрлэдэг ёсон бий. Шинжааны ойрад монголчууд загас барих улирал эхлэх үед нуур тахих ёслол явуулдаг заншилтай (Пэрлээ Б. 2013). Сычунь мужийн “И” үндэстний өөртөө засах жөөгийн Ян Юань шайнд суурьшсан монголчууд загас идэхийг тас цээрлэдэг. Нутгийн хүмүүсийн хуучилснаар “Эрт цагт эзэн Чингис хаан нэгэн мөрнийг гатлахад загас нь хөөрөг болж, хааны амийг аварсан гэнэ. Тэгээд дээдсийн амийг аварсан болохоор загасыг маш хүндэтгэн үзэж, загас идэхийг тас цээрлэдэг болж гэнэ. Тухайн нутагт загас идэхийг шаардвал шууд гэрээсээ хөөж гаргадаг заншилтай гэнэ (Үй Шань. Сичуань нутгаар аялсан тэмдэглэлээс). Үүнд: Загас нь хийсвэр шинжтэйгээс нэн бодтойжиж, загасыг шүтэн дээдэлдэг зан үйл болж эхэлжээ. Эдгээр заншил ёсноос загасыг лусын амьтан гэж хүндэтгэдэг буюу амын үүсгэл гэж үздэг үзэл ойлголт тод томруун ажиглагдана.

Буриад зэрэг угсаатны дунд “Загас сэтэрлэх” заншилтай байсан сонирхолтой мэдээлэл бий. “Буриадын нэрт бөө нар загас сэтэрлэдэг байсан. Гяламын (загасы нэр) заламд гуулин холбоо зүүлгэн чимэглээд усанд нь тавьдаг. Иймэрхүү содон тэмдэгтэй загасыг хөндөж

болдоггүй заншилтай (Аюурзана Г. 2016). Хүрээ хошууны монголчууд хүн хар өвчин тахалтай болоод сайн болохгүй бол лам буюу үзмэрчид үзүүлж, “лус тахих хэрэгтэй байна” гэвэл тэр тахилгын ёслолыг явуулдаг байна. Тэр нь зохих тооны загас жараахайг худалдан аваад нуур цөөрөмд тавих буюу лам залж, ном уншуулан лус тахих үйлийг гүйцэтгэдэг (Сарантуяа. 2018). Иймэрхүү заншлыг олонхын нутагт “Амь өршөөх” гэж нэрлэдэг. Ихэнхдээ сүм хийдээс зохион байгуулан явуулдаг. Голдуу бурхан шашны нүгэл хилэнцээ арилгах гэсэн үзэлтэй төстэй юм. Гэвч энэхүү заншлыг эртний бөө мөргөлийн “Загас сэтгэрлэх” заншлаас улбаатай гэж таамаглаж болмоор байна. Эртний монголчуудын гол шүтлэг болсон бөө мөргөлийн далдын хүч, монгол ардын гүн ухааны сэтгэлгээнд байгал ертөнц, түмэн бодистой хэрхэн холбогдож, хэрхэн харьцдаг, ухамсарт сэтгэлгээ нь загасны зан үйлд ил тодорхой тусгагдаж чаджээ.

Дүгнэлт

Монголчуудын хувьд байгаль дэлхий, араатан жигүүртний дунд аж төрж байгаа хүн өөрт нь үгүй ер бусын авьяас чадал, мөн тэнгэрт нисэх, усанд шумбах зэрэг хүнээс илүү дээгүүрт санагдам тийм ид шидтэй амьтан, араатан, жигүүртэн шувуу, загас жараахай тэргүүтнийг гайхан бишрэхийн улмаар эртний монголчуудын үзэл санааны ертөнцөд гүн нөлөөлж, тэдний аман зохиолын эл төрөл жанар, өдөр тутмын зан үйлд нь бүр тод томруун тусгагджээ. Загас нь монголчуудын өнөр, өсөлтийн хүслийг илтгэхээс гадна шүтлэг бишрэлийн ухамсартай ч холбогддог. Ялангуяа эртний домог сэтгэхүйн нөлөө ба тотем шүтлэгийн мөр сүүдэр гүн гүнзгий харагдана.

Номзүй

- Амгалан А. 1994. *Эртний Монгол орон дахь загасны аж ахуй*. Зуу-Удын Монгол үндэстний тусгай мэргэжлийн сургуулийн Эрдэм шинжилгээний сэтгүүл. №2.
- Аюурзана Г. 2016. *Бөөгийн домог*. ӨМШУТХХ.
- Бадамхатан С. 2012. *Хөвсгөлийн дархад ястан*. Үндэстний Хэвлэлийн Хороо. 2009. 2011.
- Баяр. *Монголын нууц товчоо*. ӨМАХХ.
- БНМАУ-ын түүх. 2009. 1-р боть. ӨМАХХ.
- Владимирцов Б.Я. *Монголчуудын нийгмийн байгууллын түүх*. ӨМАХХ. 2012.
- Далай Ч. *Монголын түүх*. Тэргүүн дэвтэр. ӨМАХХ. 2012.
- Лувсанчойдон. *Монголын зан аалийн ойлбор*. ӨМАХХ. 1981.
- Нармай Ч. *Өвөрмонголын аман үлгэрийн чуулган*. ӨМАХХ. 2008.
- Пэрлээ Б. *Монголчуудын оюуны соёл*. ӨМАХХ. 2013.
- Төмөрбөх. *Алишаа монголчуудын аман үлгэрийн чуулган*. ӨМАХХ. 2004.
- Сарангэрэл. *Дээд монголын зан ааль*. ӨМАХХ. 2012.
- Сарантуяа. *Хүрээ монголчуудын лус шүтлэг ба түүний соёлын утга*. 2018. Хятад улсын Монгол судлал. №3.
- Сарнай Ч. *Алишаа зүүн хошууны аман үлгэр*. ӨМСХХХ. 2013.
- Хорлоо П. *Монгол ардын явган үлгэр*. 1980. Монгол хэл бичгийн ажлын лавлах. №1
- Хун Рэн Юань. *Манж түнгүс төрөл хэлтний домгийн судлал*. Хармөрөн АХХ. 2000.
- Хүрэлшаа. *Хорчины газар усны домгийн тухай*. 1993. Монгол хэл утга зохиол. №6.
- Үй Шань. *Сичуань нутгаар аялсан тэмдэглэлээс*.
- Цэрэнжав. *Монголын эртний зан үйл*. Баян хэвлэлийн компани. 2007.
- Цэрэнсодном Д. *Монгол ардын үлгэр*. ӨМСХХХ. 1989.
- Цэрэнсодном Д. *Монгол ардын домог үлгэр*. ӨМСХХ. 2013.